



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#1

2022 он

III сар

Сар тутмын хэвлэл

<http://www.mier.mn>

## Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн шинэ бүтцээр ажиллаж эхлэв

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 сарын 31-ний өдрийн 407-р тогтоолоор Боловсролын Хүрээлэнг Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн болгон өргөтгөн баталсан байна. Үүнтэй уялдуулан БШУЯ-ны сайдын А/10 тушаалаар тус байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлав. 3-р сарын 1-ний өдрөөс эхлэн тус бүтцээр ажиллаж эхэллээ.

Хүрээлэнгийн зорилт нь Монгол Улсад боловсролын хөгжлийн асуудлаар


суурь боловсролын бодлого, төлөвлөлт, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, боловсролын бодлого төлөвлөлт, боловсролын эдийн засаг, менежмент, хүний хөгжил болон сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүн, боловсролын хөгжлийн ирээдүйн чиг хандлагын чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрхлэх, байгууллага, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний үр дүнгийн мэдээллээр үйлчлэхэд оршино.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн зохион байгуулалтын бүтцийн зураг.



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага байна.



## ҮНЭТ ЗҮЙЛС

### Чанартай судалгаа

Боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа

### Судалгааны ур чадвар, чадавхи

Үндэсний хэмжээнд судалгаа хийх чадавхи, зах зээлд өрсөлдөх, улмаар тэргүүлэх чадвар

### Туршлага

60 жилийн хугацаанд тасралтгүй ажиллаж ирсэн арвин их туршлага

### Хүмүүнлэг, хамтын ажиллагаа

Олон Улсын түвшинд хамтран ажиллах чадвар, чадавхи

### Мэдлэгт суурилсан шинжлэх ухаанч хандлага

Мэдээллийг боловсруулах, мэдлэг бүтээх суралцагч байгууллага

## ЗАРЧИМ

### Шинжлэх ухаанч байх зарчим

Орчин үеийн шинжлэх ухааны үзэл баримтлал, арга зүйг хэрэглэх

Судалгаа баталгаа, нотолгоотой байх

Бүтээл үр өгөөжтэй байх

### Хүмүүнлэг байх зарчим

Хувь хүний болон хамт олны хүсэл эрмэлзлийг хүндэтгэх

Эрдэм, судалгааны академик эрх чөлөө, ёс зүйг дээдлэх

Бүтээл хүний болон нийгмийн сайн сайханд зориулагдсан байх

### Чанартай, үр ашигтай байх зарчим

Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нь боловсролын үйлчилгээний чанарын шаардлагыг хангах

Боловсрол, сургалтын судалгаа арга зүйгээр боловсролын салбарын бүх шатны ажилтнуудад үйлчлэх

Боловсролын судалгааны мэдээллийг олон нийтэд түгээх сурталчлах



## Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн ажилтнуудын хамтын ажиллагааг дэмжих хэлэлцүүлгийг зохион байгуулав



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн дүрэм, зохион байгуулалтын еөрчлөлттэй холбоотой боловсрол судлал, боловсролын хөгжилд тус хүрээлэнгийн үүрэг оролцооны талаар судлаачид ажилтнууд санал солилцох, ойлголтоо нэгтгэх зорилгоор

2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулав.

Тус үйл ажиллагааны хүрээнд байгууллагын алсын хараа, хөгжлийн чиг хандлага, зорилго, зохион байгуулалтыг танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэв.



### Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн болон Монгол Улсын Их Сургуулийн удирдлагууд 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр үйл ажиллагааны зорилго, зорилтод үндэслэн харилцан тохиролцож, хамтран ажиллахаар САНАМЖ БИЧИГТ гарын үсэг зурлаа.

### Захиргааны зөвлөлийн хурал

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Захиргааны зөвлөлийн хурал 2022 оны 3 дугаар сард нийт 4 удаа хуралдаж, 13 асуудал хэлэлцэж, 16 шийдвэр гаргасан.



## ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАЛТ, ЦАХИМ СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН СЕКТОР



[www.sites.google.com/view/zuvlumj2020](http://www.sites.google.com/view/zuvlumj2020) сайтаар дамжуулан 3000 гаруй багш нарт хэрэгцээт файл, мэдээллээр хангав.

Багш, судлаачдын статистик мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр MS-Excel макро бэлтгэв.

БСҮХ-ийн цахим санд ([www.content.mier.mn](http://www.content.mier.mn)) II шатны зарим судлагдахууны бие даан суралцах ажлын дэвтрүүдийг байршуулж 10000 гаруй хүмүүст хүргэсэн.

Office 365 буюу хэрэглээний программыг байгууллагын ажилтнууд ашиглаж эхэллээ.

## ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СУДАЛГААНЫ СЕКТОР



Монгол хүүхдийн цогц хөгжлийн оношилгооны суурь судалгааны 2 дахь шатны судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны 1 болон 2-р шатны судалгааны өгөгдөл боловсруулалт, өгөгдлийн сангийн бүрдүүлэлт хийж дуусгав.

Монгол хүүхдийн цогц хөгжлийн оношилгооны суурь судалгааны 2 дахь шатны судалгааны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотойгоор 6-17 насны 700 гаруй 14518 хүүхдийн танин мэдэхүйн даалгаврыг оноожуулах, шивэх, нийгэмшил, бие бялдрын мэдээллийн санг бүрдүүлэв.

## БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ СУДЛАЛЫН СУДАЛГААНЫ СЕКТОР



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Боловсролын хөгжлийн ирээдүй судлалын судалгааны сектор нь 2022 оны нэгдүгээр сард БШУЯ-ны сайдын тушаалаар байгуулагдсан шинэ сектор юм. Уг сектор нь насан туршдаа суралцахуй, гамшгийн үеийн боловсрол, боловсролын цахим шилжилтийн талаарх дэлхий нийтийн чиг хандлага, бодлого, зорилтыг тодруулах, сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээ, арга зүй, хэрэглэгдэхүүний хөгжлийн

судалгаа хийх, түүнийг боловсрол, сургалтад нэвтрүүлэх бодлогын зөвлөмж боловсруулах зорилгын хүрээнд ажиллаж эхэллээ.

### Насан туршдаа суралцахуйн талаарх дэлхий нийтийн чиг хандлага, бодлого, зорилтод хийсэн дүн шинжилгээний хэсгээс ...

Насан туршдаа суралцахуй нь боловсролын аль нэг хэлбэр, агуулга, нийгмийн бүлэгт хамааралгүй бүх хүнд боловсролын үйлчилгээг бүхий л арга хэлбэр, агуулгаар олгож болно хэмээн үзэж байна.

Насан туршдаа суралцахуйд чиглэсэн боловсролын тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах чиглэлээр бодлого, стратегийг хэрэгжүүлэхийг олон улсын байгууллагууд хувь улс орнуудад зөвлөмжилж байна. Хүний сурах язгуур эрх нь зөвхөн суралцахуйн тодорхой цаг үеэр хязгаарлагдахгүй, насан туршид үргэлжлэх үзэл хандлагыг Монгол Улс чанарын шинэ түвшинд дахин авч үзэж байна.

## БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГААНЫ СЕКТОР

### “Багшийн мххт-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх удирдамж боловсруулах үндэсний сургалт”




2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 4 сарын 1-ний өдрүүдэд ШУТИС-ийн 8 дугаар байрны ОУЭШ-ний хурлын танхимд “Багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх удирдамж боловсруулах үндэсний сургалт” зохион байгуулагдсан.

Бангкок дахь ЮНЕСКО-ийн төлөөлөгчийн газар 2018 оноос эхлэн хэрэгжүүлж буй “Ази, Номхон далайн бүс нутгийн цахим иргэний чадавч бэхжүүлэх” төслийн хүрээнд Багшийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх удирдамж боловсруулах сургалтыг зохион байгуулж байна.

### ESD.MN вебсайт хөгжүүлэх, дизайн гаргах ажлын явцыг хянах, туслах, агуулга цуглуулж, оруулах багийн ажил

Монгол Улсын Засгийн газар болон Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн II үе шатыг хэрэгжүүлэх тухай гэрээний дагуу уг төслийг Швейцарын Хөгжлийн Агентлагийн техникийн буцалтгүй тусламжийн хүрээнд санхүүжүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Боловсрол Шинжлэх Ухааны яам (БШУЯ) хамтран хэрэгжүүлж байгаа билээ.



### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулах нь” тандалт судалгааны үр дүнд суурилсан хэлэлцүүлэг оролцлоо



ХБХХЕГ, БЗД-ийн ЗДТГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулах нь”

тандалт судалгааны үр дүнд суурилсан хэлэлцүүлэгт Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Тэгш хамруулах боловсролын судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиун

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар баримталж буй бодлого, хууль эрх зүйн орчин”-ы талаарх танилцуулгыг хийлээ.

## СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ, СУРАХ БИЧГИЙН СУДАЛГААНЫ СЕКТОР

### Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт туссан чадварын шинжилгээ

Отгонтуяа, С. Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн дизайн, зураг зүйн болон дизайн зураг зүйн багш бэлтгэх хөтөлбөрийн агуулгын харьцуулсан шинжилгээ хийж үр дүнгээр нь эрдэм шинжилгээний хамтарсан илтгэл бичив. ([otgontuya@mier.mn](mailto:otgontuya@mier.mn))

“ЕБС-ийн багш бэлтгэх бодлого ба дизайн зураг зүйн багш хөтөлбөрийн агуулгын харьцуулсан судалгаа” сэдвээр МУБИС, Дээд боловсролын чанарын баталгаажуулалт сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэхээр (МУБИС-ийн дизайн зураг зүйн тэнхимийн эрхлэгч Р.Гоцбаяртай хамтарсан) илтгэл илгээв.

### Тэгш хамруулах боловсролын сургалтын хөтөлбөрийн шинжилгээ

МУБИС-ийн тусгай хэрэгцээт боловсролын багш бакалаврын сургалтын хөтөлбөр, БМДИ-ийн тэгш хамруулан сургах багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хийсэн шинжилгээний тайланг хэлэлцүүлгийн үр дүнгээс гарсан зөвлөмжийн дагуу сайжруулалт хийж, эцэслэв.

### Хос хэлний СХИС аргыг турших гарааны судалгаа

**Ажлын явц:** Судалгааны цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж, тайланг нэгтгэж байна. Хос хэлээр суралцдаг ЕБС-ийн 4, 6 дугаар ангийн сурагчдын эх хэл (казах хэл) монгол хэлний сорилын боловсруулалтыг хийж байна. Сорил нь унших, бичих, ярих, сонсох чадварын даалгавруудыг багтаасан.

**Үр дүн:** Судалгааны тайлан гарч, хос хэлний СХИС аргын туршин нэвтрүүлж буй туршилтын сургуулиудын 4, 6 дугаар ангид хос хэлний нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах ажил хийгдэж байна.

**Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх /ЭША Х.Гансүх/** эрдэм шинжилгээний хуралд “Монгол улс дахь тува хэлний заах арга зүй” нэртэй илтгэлээ хэлэлцүүлэн эрдэм шинжилгээний хуралд оролцсоноор багшлах арга зүйн талаар туршлага солилцов. ([gansukh@mier.mn](mailto:gansukh@mier.mn))

### Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах үйл ажиллагааны судалгаа

Судалгааны явцад туршилтын цэцэрлэгийн 12 бүлгийн багш, 12 ээлжийн багшийн ажлын байрандаа хийж гүйцэтгэж байгаа ажлын жагсаалт, цагийн зарцуулалтыг ажиглалтын хуудаст тэмдэглэн цуглуулсан. Ирсэн мэдээллийг шалгах, кодлох ажлыг хийж эхлээд байна.

Мөн 12 хяналтын цэцэрлэгийн 12 бүлгийн багшийн ажлын байрны зураглалыг тандах судалгааны мэдээллийг 4 сард цуглуулах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэхээр ажиллаж байна.

### Цэцэрлэгт ажиллаж байгаа ээлжийн багшийн ажлын зураглал тандах ажиглалтын судалгаа 2022/03/21-25



СӨБ-ын түвшинд цэцэрлэгийн ээлжийн багш ажиллаж эхэлсэнтэй холбоотой цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохоор ээлжийн багш ажлын байрны тандах судалгааны ажлыг эхлүүлэв.

### Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” сургалт

Хөвсгөл аймгийн БШУГ-ын захиалгаар 2022 оны 3 дугаар сарын 21-29-ний өдрүүдэд эрдэм шинжилгээний ажилтнууд “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” сэдвийн хүрээнд тус бүр 90-180 минутын сургалтыг 1013 багш, 78 удирдах ажилтанд зохион байгуулав.

**“Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцүүлэв**




“Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн төслийн хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт БШУ-ны сайд Л.Энх-Амгалан, БЕГ-ын дарга С.Ням-Очир, БШУЯ-ны Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ж.Ганбаатар, БШУЯ-ны СӨБ-ын хэлтсийн дарга Ж.Мягмар, БСҮХ-ийн захирал, доктор М.Итгэл нар болон боловсрол, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагуудын эрдэмтэн, судлаачид, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцов.

Хөтөлбөрийн төслийг БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Монголхатан, “Торниун” ТББ-ын судлаач Г.Ариунсанаа нар танилцуулж, БСҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор С.Санжаабадам удирдан чиглүүлэв.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос нийт 38 асуулт, 53 санал ирүүлсэн ба оролцогчдын асуулт, дэвшүүлсэн саналыг үндэслэн “Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг сайжруулж байна.

**Байгууллага болон судлаачдын бүтээл дэлхийн түвшинд**



2022 оны 3 сард манай байгууллага хүүхдийн унтах цагтай холбоотой кейс судалгааг хийв. Судалгаанд I-XII ангийн 811 хүүхдийг түүвэрлэн хамруулав.


ЕБС-ийн сурагчдын унтах цагийн үргэлжлэх хугацаа нь ЕБС-ийн хичээл эхлэх цагтай хэрхэн уялдаж байгааг авч үзэв.

Судалгааны үр дүнгээс харахад, нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 58 хувь 22-23 цагийн хооронд унтдаг байна. (Боловсролын хүрээлэн, Монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгаа, 2018 он)


Орой унтдаг цаг нь 11-14 настай хүүхдүүдийн хувьд танин мэдэхүйн чадвар болох анхаарлын төвлөрөл сонорын ой тогтоолт, сэтгэхүйн задлан шинжлэх нэгтгэх чадвар, нийгэмшлийн чадвар өөрийн зан төлөвийг удирдах, хянах сэтгэл санааны тогтвортой байдал болон биеийн өсөлтөд нөлөөлдөг.

Хүүхэд эрт унтах тусам биеийн өндрийн үзүүлэлт, сэтгэл санааны тогтвортой байдал, зан төлөвөө удирдах, эцэг эхтэйгээ харилцах чадвар нь эерэг түвшинд байдаг байна.


**ҮР ДҮН: I-V ангийн сурагчдын унтах цагийн үргэлжлэх хугацаа**



**ҮР ДҮН: VI-XII ангийн сурагчдын унтах цагийн үргэлжлэх хугацаа**



**ҮР ДҮН: Зарим орны сурагчдын унтах цагийн үргэлжлэх хугацаа**



**ЗӨВЛӨМЖ: Таны хүүхэд хэдэн цагт унтвал зохистой вэ?**

